



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР



Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ


2024 оны 2 дугаар сарын байдлаар

Мөрөн сум

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 2 сарын байдлаар 319 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 34 тохиолдол буюу 10.7%-иар буурсан байна. Төрөлт Бүрэнтогтох, Рашаант, Тариалан, Төмөрбулаг, Улаан-Уул, Цагаан-Уул, Цагаан-Үүр, Цэцэрлэг сумдад өсч, бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 63,9% байна.




ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 2 сарын байдлаар нийт 320 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 34 тохиолдолоор буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 2.8 хувь /9/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 96.9 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2024 оны эхний 2 сард нийт 8094 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0,04 хувь нь тураалтай, 0,1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 65.4 хувь нь Д амин дэм, 1.9 хувь нь олон найрлагат бичил тэжээл, А амин дэмийг 156 хүүхэд хэрэглэсэн байна.

НЯЛХАСЫН ЭНДЭГДЭЛ


Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 2 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдсэн нь 2023 оны мөн үеэс 2 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөнд 6.3 ногдож байна. Нийт 2 тохиолдол буюу 100 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд 2-уулаа эмэгтэй хүүхэд байна.

Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:



1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2024 оны эхний 2 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 1 тохиолдлоор өссөн байна. 1000 амьд төрөлтөнд 9,4 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл амьсгалын тогтолцооны эмгэг 2, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 1 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан,
2024 оны эхний 2 сарын байдлаар



НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

2024 оны эхний 2 сарын байдлаар 106 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй адил тохиолдол бүртгэгдсэн байна. Нийт нас баралтын 16,0 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 41,2 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралт 8 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 4 тохиолдолоор буурсан, нийт нас баралтын 7,5 хувийг эзэлж, 10000 хүн амд 0,6 ногдож байна. Хорт хавдрын нас баралт 38 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 7 тохиолдлоор өсч, нийт нас баралтын 35,8 хувийг эзэлж, 10000 хүн амд 2,8 ногдож байна.


Нас баралтын мэдээлэл,
2024 оны эхний 2 сарын байдлаар



Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 3.2
2. Хавдар-2.8
3. Гадны шалтгаант өвчлөл- 0.6
4. Амьсгалын тогтолцооны өвчин-0.4
5. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-0.2

Осол гэмтлийн шалтгаант нас баралт, 2024 оны эхний 2 сарын байдлаар




Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 2 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 552, эсийн шинжилгээ 780 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 13 нас баралт буюу 53,8% эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү бүртгэгдээгүй байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 6 тохиолдол байна.


АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 2 сарын байдлаар амбулаторид нийт 96389 үзлэг хийгдсэнээс 39.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 44.6 хувийг өвчний учир амбулаторид, 5.5 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 7.4 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 3.0 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.

Амбулаторийн үзлэгийн төрөл



Амбулаторийн үзлэг, 2023-2024 оны эхний 2 сарын байдлаар



ЖИРЭМСЭНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 309 жирэмсэн эмэгтэйчүүдээс 92,6 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд хамрагдсан байна. Цусны шинжилгээнд 89.0 хувь нь хамрагдаж, 0.7 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 2 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 90.3 хувийг, тэмбүү болон ХДХВ илрүүлэх шинжилгээнд 95.8 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-1 трихомониаз-3, тэмбүү-7 тохиолдлыг тус тус бүртгэн эмчилсэн байна.



ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2024 оны эхний 2 сарын байдлаар халдварт бус өвчлөл 15737 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 14349 тохиолдлоор өссөн байна. 10000 хүн амд 1143.4 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 203 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1.3 хувийг эзэлж, 10000 хүн амд 14.7 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-252.9
2. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 248.7
3. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 195.0
4. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-109.4
5. Мэдрэлийн тогтолцооны өвчин-60.3


Стационарт нийт 5095 хүн хэвтэж эмчлүүлж, 33791 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 6.6, орны эргэлт 5.1, орны фонд ашиглалт 33.8 фонд ашиглалтын хувь 61.4 байна.


Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 2 сарын байдлаар нийт 3819 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэснээс 14.0 хувь /536/ нь алсын дуудлага, 2.1 хувь /79/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 63.7 дуудлага, АНЭ 19.1 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.

ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны эхний 2 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 7379 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 8.4 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 37.9% эрэгтэй, 62.1% нь эмэгтэй байна.

Давтан үзлэгт 191 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 13 буюу 6.8% нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 5346 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 10.3 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 39.9% эрэгтэй, 60.1% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 33 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 1 буюу 3.0% нь онош баталгаажсан байна.





ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 25623 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 58.9 хувь
- Өвчний учир үзлэг 14.9 хувь
- Диспансерийн хяналт 7.2 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 18.3 хувь
- Гэрийн дуудлага 0.6 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 13511 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 6.8 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 579 жирэмсэн эмэгтэйдгээс 90.1 хувийг эрт үед нь хяналтанд авч 87.4 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 43 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 8 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 22, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 1 тохиолдол бүртгэгдсэн байна.

ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хувийн эмнэлгүүд нийт 5991 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 10.72 хувь
- Диспансерийн хяналт 3.57 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 0,03 хувь
- Гэрийн дуудлагаар 0,02 хувь
- Өвчний учир үзлэг 85.66 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 1328 хүн хэвтэн эмчлэгдэж, 9560 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.2 орны эргэлт 4,4 ба орны фонд ашиглалт 31,6, орны фонд ашиглалтын хувь 57,4 байна.

Нийт халдварт бус өвчний 124 тохиолдлоос 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 209 тохиолдол бүртгэгдсэн байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН


Аймгийн хэмжээнд эхний 2 сарын байдлаар 145 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 10,6 ногдож байна. 2023 оны мөн үед 182 тохиолдол, 10000 хүн амд 13,3 ногдож байжээ. 10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Баянзүрх /14,8/ Бүрэнтогтох /15,8/, Тосонцэнгэл /15,7/, Төмөрбулаг /16,0/, Цагаан-Уул /13,6/, Цэцэрлэг /15,0/, Мөрөн /15,7/ суманд аймгийн дунджаас өндөр байна.

Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 61,4 хувь, сүрьеэ 3,4 хувь, амьсгалын замын өвчин 25,5 хувь, гэдэсний халдварт өвчин 9,0 арьс салтстаар халдварлах халдвар 0,7 хувийг тус тус эзэлж байна.

ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН




Нийт цочмог халдварт өвчний 56 тохиолдлоос:

- Сальмонеллэз 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит В 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Хепатит С 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Сүрьеэ 5 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор
- Ёлом 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Гар хөл амны өвчин 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 7 тохиолдлоор
- Ковид-19 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор тус тус буурч
- Цусан суулга 12 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Хоолны хордлого 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Салхинцэцэг 37 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 23 тохиолдлоор тус тус өсч
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахаруу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.





ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ

- 2024 оны эхний 2 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 56 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс цэврүүт тууралт 76.8 хувь (43), цочмог халууралт, цусархаг тууралтат 19.6 хувь (11), цочмог усархаг 1.8 хувь (1), хоолны хордлогот халдвар 1.8 хувь (1) тус тус бүртгэгдсэн байна.
- Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/




ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН

2024 оны эхний 2 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 3475 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 252.2 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 5076 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 370.9 болсон байна.



АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар)




БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 61.4% (89) тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 74.8% (136) тохиолдол бүртгэгдсэнээс:


- Тэмбүү 29 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор
- Гоноккокт халдвар 51 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 47 тохиолдлоор тус тус буурч
- Трихомониаз 9 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор өссөн байна.

Бэлгийн замын халдварт өвчин, 2024 оны эхний 2 сарын байдлаар


■ тэмбүү ■ заг хүйтэн ■ трихомониаз



Бэлгийн замын халдварт өвчин, насны бүлгээр, 2024 оны эхний 2 сарын байдлаар



БЗХӨ боловсролын түвшингээр
,2024 оны эхний 2 сарын байдлаар



ХЯНАСАН:

ДҮГНЭЛТ ХИЙСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.МӨНХ-АЮУШ
ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН П.БАЯРМАА